



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/115

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Г


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/96 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд авто машин” нийлүүлэх ажил /ДУАОНӨГ/201704035/-ын гүйцэтгэгчээр “Броун Айс” ХХК – ийг сонгон 13,000,000 /арван гурван сая / төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шууд гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу автомашин нийлүүлэхийг “Броун Айс” ХХК-ний гүйцэтгэх захирал /Б.Болортулга/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, автомашин нийлүүлэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, аймгийн ЗДТГ-ын ня-бо /Ц.Даваа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА О.ЧУЛУУНБАТ



0200337